



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 63

Даланзадгад сум

“Залуус” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Засгийн газрын 2019 оны 171, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. “Залуус” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр баталж, арга хэмжээний зардлыг жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д даалгасугай.
3. Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, хөтөлбөрийн тайланг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д үүрэг болгосугай

ХУРЛЫН ДАРГА



Б.БАДРАА

4A2210272



“ЗАЛУУС” ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Залуучуудын хөгжлийн төвүүдийг нэмж байгуулан залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа сэтгэлзүй, хөгжлийн харилцааг дэмжихэд чиглэсэн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр “Нутгийн хишиг” хөтөлбөрийн 4.3.157 дахь заалтад тусгасан.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1 дэх хэсэгт Монгол Улсын иргэн 15-34 насны хүн амыг залуучууд гэж тодорхойлсон. Манай Улсын хүн ам 2019 онд 3,2 саяд хүрч, үүнээс 1 сая гаруй нь буюу 31% нь залуучууд байгаа бол Өмнөговь аймгийн хувьд 2020 онд 71493 хүн амтай болж, үүнээс 15-34 насны 23097 залуучуудтай ба аймгийн нийт хүн амын 32,3%-ийг эзэлж байна.¹

Эдийн засаг, нийгмийн байдлын судалгаанд 2020 оны байдлаар Өмнөговь аймагт ажиллах хүчнээс гадуурх хүн ам 13659 байгаагаас 5790 нь залуучууд буюу 42,3%-ийг эзэлж байна. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 496 иргэн бүртгүүлснээс 70% нь 15-34 насны иргэд байна.

2020 онд аймгийн хэмжээнд 20-оос доош буюу 106 өсвөр насны охидууд төрж, 19-өөс доош насны 52 охин үр хөндүүлсэн байна. Бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлуудаас 45 тохиолдол нь 15-19 насны хүүхдүүд байсан ба өнгөрсөн оны мөн үеэс 8 тохиолдлоор нэмэгдсэн буюу нийт тохиолдлын 11,3%-ийг эзэлж байна.²

Аймгийн хэмжээнд 457 гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж, бүртгэгдсэн ба гэмт хэрэгт холбогдсон 385 хүн бүртгэгдсэнээс 15-34 насны залуучууд 61 хувийг эзэлж байна. Нийт гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг нийгмийн байдлаар авч үзвэл ажилгүй хүмүүс хамгийн өндөр буюу 63.8 хувийг эзэлж байна.³

Өнгөрсөн онд Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогтцэций, Ханбогд сумдын Залуучуудын хөгжлийн төв нь Амьдрах ухааны 74 удаагийн сургалт зохион байгуулж 1807 хүн хамрагдсан ба 67 төрлийн нөлөөллийн үйл ажиллагаанд 2165 хүнийг хамруулсан, цахимаар 22 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж 62952 хүнд хүргэсэн. Мөн 114 өсвөр үеийхэн, залуучуудад зөвлөгөө өгч, эрүүл мэндийн байгууллага, өсвөр үеийн клиникт 519 өсвөр үе, залуучуудыг холбон зуучилсан, мөн 15 сумын залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган давхардсан тоогоор аймгийн залуучуудын 50,2%-д нь хүрч үйлчилснээрээ улсын хэмжээнд жишиг үйлчилгээ үзүүлсэн мөн тогтмол үйл ажиллагаатай болоод байгаа билээ.

2020 онд Залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 15 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж дэмжлэг үзүүлсэн.

Өмнөговь аймаг нь уул уурхай түлхүү хөгжсөнтэй холбоотойгоор Даланзадгад, Цогтцэций, Ханбогд, Гурвантэс зэрэг сумдад хөдөлгөөнт хүн амын тоо нэмэгдсээр байна. Мөн уул уурхайн нөлөөллийн бус сумдад залуучуудын

¹ Өмнөговь аймгийн статистикийн хэлтэс

² Өмнөговь ЭМГ статистик мэдээлэл

³ Өмнөговь аймгийн 2020 оны IV улирлын нийгэм эдийн засгийн танилцуулга

оролцоо, хөгжлийн түвшин харьцангуй бага байгаа нь сумдын залуучуудыг мэдээллээр хангах, тэдэнд хүрч үйлчлэх хэрэгцээ шаардлага тулгараад байна.

Мөн дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын хүрээ манай орныг ч нөмөрч, бүх нийтэд чиглэсэн урлаг, соёл, спорт, сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой нийгмийн сөрөг үзэгдлүүд нэмэгдэж байна. Ковидын дараах үед залуучуудын нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлж, хөгжлийг дэмжих шаардлага тулгарч байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд залуучуудад тулгамдсан асуудлыг салбар салбарын төлөөлөл 632 залуучуудаас цахим байдлаар санал авч хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойллоо. Судалгаанд хамрагдсан залуучуудын 61,6 хувь нь дээд боловсролтой, 20,1 хувь нь бүрэн дунд, 10 хувь нь мэргэжлийн боловсролтой залуучууд хамрагдсан.

Судалгаанд 352 төрийн албан хаагч, 68 сурагч, оюутан 52, хувийн хэвшил болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 77, малчин 17, хүүхдээ асардаг 41 залуучууд хамрагдсан ба орлогоо нэмэгдүүлэх, орон байрны нөхцөлөө сайжруулах, спорт болон хувь хүний хөгжлийг дээшлүүлэх, ажлын байр бий болгох, сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл авах, гарааны бизнес эрхлэх гэх зэрэг асуудлуудыг тодорхойлж гаргасан.

Иймд тэдэнд тулгарч буй нийтлэг асуудал бэрхшээлийг тодорхойлж, түүнийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, залуу гэр бүлийн суурь хэрэгцээг хангахад төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх, зөв бодлого, зорилтот арга хэмжээнүүд хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Залуучуудад ээлтэй, ажиллаж, амьдрах, авьяас чадвараа нээн хөгжүүлэх орчин нөхцөлийг бий болгож нийгмийн хөгжилд залуусын оролцоог нэмэгдүүлэх замаар залуучуудыг эх оронч үзэлтэй, түүх, өв соёлоороо бахархдаг, гэр бүлийн болон нийгмийн өмнө хариуцлага хүлээх, эрх үүргээ ухамсарладаг эрүүл, хүнлэг иргэн болоход нь дэмжлэг үзүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

- 3.1. Залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлж хувь хүний хөгжлийг дэмжин, боловсрол, мэдлэг хандлагыг дээшлүүлж оролцоог нэмэгдүүлэх;
- 3.2. Залуучуудад эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлж, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх;
- 3.3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих;
- 3.4. Залуучуудад ээлтэй ажиллаж, амьдрах, авьяас чадвараа нээн хөгжүүлэх орчныг бүрдүүлэх;

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, уялдаа

4.1. Хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

4.2. Дараах хөтөлбөрүүдтэй уялдаж хэрэгжүүлнэ.

4.2.1 Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр

4.2.2 “Хөгжлийн гүүр” хөтөлбөр

4.2.3 “Сурагч солилцоо” хөтөлбөр

4.2.4 “Түрээсийн орон сууц” хөтөлбөр

4.2.5 “Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая” хөтөлбөр

4.2.6 “Өсөлтийг өрх бүрд” хөтөлбөр

4.2.7 “Цахим Өмнөговь” хөтөлбөр

Тав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1 Залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлж хувь хүний хөгжлийг дэмжин, боловсрол, мэдлэг хандлагыг дээшлүүлж оролцоог нэмэгдүүлэх;

5.1.1 Залуучуудын хөгжлийн төвүүдийг сумдад шинээр байгуулж залуучуудын хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхолд нийцсэн олон талт үйлчилгээг үзүүлэх;

5.1.2 Залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад тусгах;

5.1.3 Авьяас, сурлага, урлаг, спортын амжилт, мэргэжлээрээ үе тэнгийнхнээ манлайлагч залуучуудыг урамшуулж, олон улсын хэмжээний уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх;

5.1.4 Малчин залуучуудын амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

5.1.5 Залуучуудын дунд гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэх, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх, сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах;

5.1.6 Залуучуудын хүмүүнлэгийн болон сайн дурын ажилд оролцох оролцоог нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх;

5.1.7 Залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх, түүх, соёлын өвийг хамгаалах, ардын урлаг, ёс заншил, уламжлалт зан үйлийг хөгжүүлэхэд залуучуудын оролцоог хангах;

5.2 Залуучуудад эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлж, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх;

5.2.1 Залуучуудад архи, тамхи, мансууруулах бодисын хор уршгийг ойлгуулах, эрүүл, зөв амьдралын дадал хэвшлийг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах;

5.2.2 Залуучуудыг бүх нийтийн биеийн тамирын арга хэмжээнд хамруулах, шинэ санаачилга, уриалга гаргаж буй залуучуудыг дэмжих;

5.2.3 Зорилтот бүлгийн залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй, сургууль завсардсан, ажилгүй, өсвөр насны залуучуудад хүрч үйлчлэх, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах;

5.2.4 Өсвөр үе, залуучуудад бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт, бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх, жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн талаарх мэдлэг ойлголт, хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг сурталчлах;

5.2.5 Залуучуудын гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа, уламжлал, зан заншлын тухай сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх

5.2.6 Өсвөр үед ээлтэй төвүүд, өсвөр үеийн кабинетын үйл ажиллагааг идэвхжүүлэх

5.3 Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих;

5.3.1 Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалтын болон дээд боловсролын байгууллагын төгсөгчдөд мэргэжил сурталчлах, хөдөлмөрийн үзэсгэлэн яармагийг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулах;

5.3.2 Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн, нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлсэн компани, аж ахуйн нэгж, байгууллагуудыг цахим сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах;

5.3.3 Зорилтот бүлгийн залуучууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх, үе шаттай сургалтад хамруулан чадавхжуулж тохирох ажлын байранд зуучлах, чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллээр хангах ажлыг тогтвортой хэрэгжүүлэх;

5.3.4 Олон Улсын тэргүүн туршлага, өндөр технологи, шинэ санааг орон нутагт нутагшуулж, залуучуудын гарааны бизнесийг дэмжих;

5.3.5 Мэргэжлийн ур чадвараа сайжруулах, шинэ мэргэжил эзэмших сургалтад ажилгүй залуучуудыг хамруулах

5.4 Залуучуудад ээлтэй ажиллаж, амьдрах, авьяас чадвараа нээн хөгжүүлэх орчныг бүрдүүлэх;

5.4.1 Залуу ажилтнуудын ажлын байран дахь эрх, үүргийг хангах, тогтвортой ажиллуулахад чиглэсэн сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх тухай сургалт, нөлөөллийн арга хэмжээг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудыг хамруулан зохион байгуулах;

5.4.2 Залуучуудад чиглэсэн нөлөөллийн болон сургалтын төрийн зарим чиг үүргийг залуучуудын эрх ашгийг төлөөлөх чадвар бүхий, мэргэшсэн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх;

5.4.3 Зорилтот бүлгийн залуучуудын тэгш оролцоог нэмэгдүүлэхэд төрийн бус байгууллагуудыг оролцуулах;

5.4.4 Орлоготой нь нийцсэн, уян хатан төлбөрийн нөхцөл бүхий орон сууцны талаарх мэдээллийг залуучуудад хүртээмжтэй болгох, хөтөлбөрт хамрагдах залуучуудын хувийг нэмэгдүүлэх;

5.4.5 Орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулж, үр бүтээлтэй ажиллаж, амьдарч байгаа залуучуудыг дэмжих, алдаршуулах.

5.4.6 Залуучуудын авьяас чадвар, бие бялдар, сэтгэхүйг хөгжүүлэхэд шашин болон улс төрөөс ангид урлаг, соёл, спортын арга хэмжээнд залуучууд оролцох, эдгээр арга хэмжээг зохион байгуулсан хуулийн этгээдийг дэмжих;

5.4.7 Залуучуудын хүсэл сонирхолд нийцсэн тэдний авьяас чадварыг нээн хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын төвүүдийн үйл ажиллагааг дэмжих;

Зургаа. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Нэгж	Суурь түвшин (он)	Зорилтот түвшин (он)		Хэрэгжүүлэх байгууллага
				2020	2021	2024	
1.	1-р зорилтын хүрээнд	Шинээр байгуулагдсан залуучуудын хөгжлийн төвийн тоо	тоо	3	6	12	АЗДТГ, ГБХЗХГ
2.		Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын тоо	тоо	6916	5000	10000	ГБХЗХГ
3.		Хөтөлбөрт хамрагдсан залуучуудын хувь	хувь	48	50	85	ГБХЗХГ, НТБТ, ХХҮГ, ТББ
4.	2-р зорилтын хүрээнд	Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан оюутны тоо	тоо	-	1000	4000	ЭМГ
5.		Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн тоо	тоо	150	800	3000	ЭМГ
6.		НҮЭМ-ийн өсвөрийн сургагч багшийн тоо	тоо	125	100	400	ГБХЗХГ, Өсвөр үеийн кабинет
7.		Өсвөрийн клиникээр үйлчлүүлсэн өсвөр насны хүүхдийн тоо	тоо	1037	1100	4400	Өсвөр үеийн кабинет
8.			тоо				
9.	3-р зорилтын хүрээнд	Гарааны бизнес эрхэлж буй залуучуудын тоо	тоо	0	10	40	ХХҮГ
10.		Загвар төвөөр үйлчлүүлж ажилд зуучлагдсан залуучуудын тоо	тоо	524	600	2400	ХХҮГ
11.		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих модуль сургалтад хамрагдсан залуучуудын тоо	тоо	236	250	800	ХХҮГ
12.	4-р зорилтын хүрээнд	Зохион байгуулсан хуримын тоо	тоо	20	25	100	ГБХЗХГ
13.		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд оролцоход дэмжлэг үзүүлэх "Хувийн туслах"-ын тоо	тоо	10	20	80	Бие даан амьдрах төв
14.		Түрээсийн орон сууцанд хамрагдсан залуучуудын тоо	тоо	33	38	150	ГБХЗХГ
15.		Угийн бичиг хөтөлдөг залуу гэр бүлийн тоо	тоо	46	92	368	НТБТ

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

7.1 Улсын төсөв

7.2 Орон нутгийн төсөв

7.3 Олон улсын байгууллагын хандив, төсөл хөтөлбөр

7.4 Бусад эх үүсвэр

Найм. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, оролцогч талуудын оролцоо, хүлээх үүрэг

Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтыг аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг болон Засаг даргын Тамгын газар хариуцаж ажиллана.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, мэдээллээр хангах, хяналт тавих ажлыг Нийгмийн бодлогын хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран гүйцэтгэнэ.

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар нь нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, санхүүжүүлэх асуудлыг хариуцна.

Сумын Засаг дарга нар тухайн сумын нутаг дэвсгэртээ арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлж ажиллана.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсрол, соёл урлагийн газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Хөгжимт жүжгийн театр, Насан туршийн боловсролын төв, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газар, “Буянт хотхон” улсын төсөвт үйлдвэрийн газар, Номын сан, Политехникийн коллеж зэрэг төрийн байгууллагууд хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.

Иргэд, олон нийт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцоно.

Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, хэвлэл мэдээллийн байгууллагууд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтарч ажиллана.

Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг бүх шатны Засаг дарга, нийгмийн салбарын байгууллагууд хамтран гүйцэтгэж үр дүн, тайланг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

9.2. Аймгийн Засаг даргын Тамгын газар хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн эхний улиралд багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулна.

9.3. Хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.4. Хөтөлбөрийн хэрэгжилтэд 2 жилд нэг удаа хөндлөнгийн хяналт, шинжилгээ үнэлгээ хийлгэж үр дүнг Засаг даргын зөвлөлд танилцуулна.